

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН БАЯНГОЛ СУМЫН 2-Р БАГИЙН НУТАГТ БАЙРЛАХ
“БАГА МУХАРЫН АМНЫ ДУНД ХЭСГИЙН ХШ-100-108 ШУГАМЫН ХООРОНД
ОРШИХ АЛТНЫ ШОРООН ОРДЫГ АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

АШИГТ МАЛТМАЛ АШИЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР:

MV-022116

АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 6622844

УЛААНБААТАР 2026 ОН

ГАРЧИГ

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2
ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ..	11
БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ.....	12
БҮЛЭГ 1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	13
БҮЛЭГ 2. УУРХАН НӨХӨН СЭРГЭЭЛТ, ХААЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....:	19
БҮЛЭГ 3. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ	22
БҮЛЭГ 4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	23
БҮЛЭГ 5. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	24
БҮЛЭГ 6. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	25
БҮЛЭГ 7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	27
БҮЛЭГ 8. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	30
БҮЛЭГ 9. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	38
БҮЛЭГ 10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	40
БҮЛЭГ 11. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ АЖИЛД ЗАРЦУУЛАГДАХ ЗАРДЛЫН УРЬДЧИЛСАН ТООЦОО.....	41

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Компанийн танилцуулга: Сартуул орд ХХК нь 2020 онд байгуулагдсан уул уурхайн зөвөлгөө өгөх, уул уурхайн тоног төхөөрөмжийн худалдаа, газар тариалан, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг үндэсний компани юм.

АМГТГ-ын ГУУКХ-ээс 2021 оны 9-р сарын 29-ний өдөр XV- 021935 тоот хайгуулын тусгай зөвшөөрөл олгосны дагуу Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших Овоот толгой нэртэй газар гүйцэтгэсэн хайгуулын ажлаар Бага мухарын амны дунд хэсгийн ХШ-100-аас ХШ-108-ын хооронд орших алтны шороон ордын нөөцийг тооцон ЭБМЗ-өөр батлуулсан байна.

Улмаар АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2022 оны 04-р сарын 27 өдрийн 202 тоот шийдвэрээр MV-022116 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан.

Компанийн байгаль орчны бодлого

Бидний эрхэм зорилго: Компаний үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн бүхий л үе шатанд байгаль орчинд үүсэж болох аливаа сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах талаар анхааран ажиллах, байгалийн нөөцийг удаан хугацаанд тогтвортой ашиглах нь компанийн нэн тэргүүний зорилго болно.

Бидний дээдлэх үнэт зүйлс: Компани нь уурхайн төслийг боловсруулах шатнаас үйл ажиллагааныхаа бүх хүрээнд байгаль орчны асуудлыг байнга анхаарч Монгол улс болон олон улсын хэмжээнд мөрдөж буй уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны холбогдолтой хууль, журам, гэрээ хэлэлцээрийг дагаж мөрдөнө.

Эх орон, төрсөн нутаг, усаа хайрлан хамгаалах нь компанийн бүх ажилчид албан хаагчдын үнэт зүйл болох учиртай.

Баримтлах бодлого: Манай компани нь дараах зорилтуудыг дэвшүүлж ажилладаг. Үүнд:

Байгалийн нөөц баялагийг урт удаан хугацаанд тогтвортой, үр ашигтай зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар баримталж ирсэн төрийн бодлогыг хэрэгжүүлж, эрх бүхий байгууллагаас баталсан байгаль орчны стандарт, хэм хэмжээ, дүрэм журмыг чанд сахин биелүүлж, дотоодын болон хөндлөнгийн байгаль орчны хяналтыг тогтмол гүйцэтгэх;

Улсын болон орон нутгийн хэмжээнд тогтвортой үйл ажиллагаа явуулдаг байгаль орчныг хамгаалах чиглэлийн төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах;

Байгалийн нөөц ашиглалтын үр ашгийг өндөр түвшинд байлгах зорилгоор тогтмол судалгаа шинжилгээ явуулж орчин үеийн үр ашигтай техник, технологийг үйлдвэрлэлдээ тууштай нэвтрүүлэх;

Үйлдвэрлэл, уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн иргэдийн соёл, өв уламжлалыг хүндэтгэх хамгаалах, тэдний биет өв, ёс заншлын талаархи мэдээлэл, тэдгээрийн ач холбогдлыг компанийн ажилчдад тогтмол таниулах;

**ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН
ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Төслийн байршил: Бага Мухарын амны дунд хэсгийн ХШ100-108 шугамын хооронд орших алтны шороон орд нь Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт Улаанбаатар хотоос баруун хойш 135 км, Сэлэнгэ аймгийн төв Сүхбаатар хотоос урагшаа 185 км, Сэлэнгэ аймгийн Мандал сумын төвөөс баруун хойш 60 км, тухайн талбай орших Баянгол сумын төвөөс 40 км зайтай оршино.

Ордын нөөц: Бага Мухарын амны дунд хэсгийн алтны шороон ордын ХШ-100-аас ХШ-108-ын хооронд 2021 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайланг (Ордын нөөц 2022 оны 01 дүгээр сарын 15-ны байдлаар) ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцэж, 2022 оны 02 сарын 18-ны өдрийн ЭБМЗ-ийн хуралдааны ХХ-02-05 тоот дүгнэлтийг үндэслэн УГА¹-ны даргын 2022 оны 03 сарын 24-ний өдрийн дугаар 4-23 тушаалаар алтны нөөцийг бодитой (В) зэрэглэлээр шлихээр 78.57 кг, хими цэврээр 70.01 кг, боломжтой (С) зэрэглэлээр шлихээр 12.97 кг, хими цэврээр 11.56 кг, нийт бодитой болон боломжтой зэрэглэлээр шлихээр 91.54 кг, химийн цэврээр 81.57 кг нөөцийг ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэсэн байна. Орд нь III бүлгийн шороон ордод хамаарна.

Ил уурхай: Бага Мухарын амны дунд хэсгийн ХШ-100-аас ХШ-108-ын хоорондох алтны шороон орд нь 1 давхаргаас бүрдэнэ. Алт агуулсан элсний давхаргын дундаж зузаан 2.46 м, давхаргын урт 950.0 м, давхаргын өргөн 40.0-105.0 м, хучаас хөрсний дундаж зузаан 36.7 м байна. Ордын уул геологийн нөхцөл, элсний биетийн хэлбэр ба байршил, хучаас хөрсний зузаан зэрэгт үндэслэн ил уурхайн аргаар, автотээвэртэй гадаад болон дотоод овоолготой ашиглалтын системээр ашиглахаар ТЭЗҮ-ийг боловсруулав. Уулын ажлын төлөвлөлтөөр ил уурхайн хүрээнд 592 мг/м³ (шлихээр) алтны дундаж агуулгатай 132.6 мян.м³ элс, үүнээс бодитой (В) зэрэглэлээр шлихээр 68.49 кг, хими цэврээр 61.04 кг, боломжтой (С) зэрэглэлээр шлихээр 10.03 кг, хими цэврээр 8.94 кг, нийт бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр шлихээр 78.52 кг хими цэврээр 69.97 кг алтны нөөц өртөж байна. Ил уурхайн олборлолтын үеийн элсний бохирдлын тооцоог хийхдээ элсний давхаргын тааз болон улны талбайг тооцож улнаас 20 см, таазнаас 10 см-ээр бохирдуулж авахаар тооцсон. Ил уурхайг ашиглах явцад олборлолтын үеийн хаягдал болон тээвэрлэлтийн үеийн хаягдал үүсэхгүй байхаар тооцоход 536 мг/м³ (шлихээр) алтны агуулгатай 146.5 мян.м³ үйлдвэрлэлийн нөөц ба үүнээс 85%-ийг буюу 124.4 мян.м³ бодитой (В) зэргийн нөөц, 15%-ийг буюу 22.2 мян.м³ боломжтой (С) зэргийн нөөц тус тус эзэлж байна. Хөрс хуулалтын хэмжээ 2,790.7 мян.м³ ба хөрс хуулалтын итгэлцүүр 19.1 м³/м³ байна.


Элс угаан баяжуулах хэсэг: Алт агуулсан элсний найрлага, шинж чанар, технологийн туршилт судалгааны үр дүнд үндэслэн шороон ордын элсийг гравитацийн технологийн аргаар баяжуулах бөгөөд ашиглалтын 5 сарын хугацаанд алтны дундаж агуулга нь 0.536 г/м^3 , 146.52 мян.м^3 элс олборлон, угаан баяжуулах хэсэгт гравитацийн технологийн аргаар 92.6%-ийн металл авалттай 64.79 кг алт /химийн цэврээр/-үйлдвэрлэнэ.

Усан хангамж: Уурхайн унд-ахуйн буюу хотхоны усны хэрэглээг лицензийн талбайд байгуулсан худгаас хангана. Харин угаан баяжуулах хэсэг болон ил уурхайн усны хэрэглээг уурхайн шүүрэлтийн усыг цуглуулж хангана. Ил уурхайд шүүрч орж ирэх усыг “Их худаг”- ийн аргаар тооцоход тухайн сарын ил уурхайн карьераас хамаарч $2060.4 \text{ м}^3/\text{хон}$ буюу 23.8 л/с шүүрч орж ирэхээр байна. Энэ нь уурхайн нийт усны хэрэглээ болох 15.94 л/с -ийг хангаж байна. Ил уурхайд шүүрч орж ирэх усыг зумпанд цуглуулах ба зумпнаас угаан баяжуулах хэсгийн цэвэр усан сан руу татаж ашиглана.

Цахилгаан хангамж: Бага Мухарын амны дунд хэсгийн алтны шороон ордын цахилгааны хэрэглээг Шарын гол сумын $110/6\text{кВт}$ -ын хүчдэлтэй 21-р дэд станцаас Буянтын станц руу 11 км $6/10\text{кВт}$ -ын дэд станцаас салбарлуулан 3.8 км -ийн урттай 10кВт -ын хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын шугам татан хангахаар ТЭЗҮ-д тусгасан.

Төслийн талбайн ерөнхий мэдээлэл: Овоот толгой нэртэй MV-022116 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд орших Бага Мухарын амны дунд хэсгийн ХШ-100-аас ХШ-108-ын хооронд орших алтны шороон орд нь Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт оршино. Тус ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь Улаанбаатар хотоос баруун хойш 135 км , Сэлэнгэ аймгийн төв Сүхбаатар хотоос урагшаа 185 км , Сэлэнгэ аймгийн Мандал сумын төвөөс баруун хойш 60 км , Сэлэнгэ аймгийн сумын төвөөс зүүн тийш 40 км -т оршино. Төслийн талбай нь Нарангийн голын дунд хэсэгт, түүний зүүн гар талын салаанууд болох Их Мухарын амны эхэн хэсэг, Бага мухарын амны дунд хэсэг орчмыг хамарсан байдаг. Газар зүйн 1:200000-ны номенклатурын М-48-XXIX хавтгай, 1:100000-ны номенклатурын М-48-105 хавтгайд байрлана.

Зураг 1. Төслийн талбайн байршлын зураг



2.1. Төслийн талбайн физик газарзүй

Байгаль, цаг уурын нөхцөл: Төслийн талбай нь өвөл хавартаа хахир хүйтэн, зун намартаа чийглэгдүү сэрүүн эх газрын эрс тэс уур амьсгалтай нутагт хамаарна. Салхины ноёлох чиглэл нь өвлийн саруудад өмнө чиглэлүүдийн, хаврын саруудад баруун хойноосоо зүүн урагш чиглэлийн, зуны саруудад баруун өмнөөс зүүн хойд чиглэлийн, намрын саруудад баруун өмнөөс зүүн хойд чиглэлүүдийн давтагдал хамгийн их ба салхины дундаж хурд хаврын сард 4.3-6.4 м/с, бусад улиралд 2.5-5 м/с байна.

Жилийн дундаж агаарын температур -0.9°C ба зундаа дунджаар $+18.8^{\circ}\text{C}$, өвөлдөө дунджаар -25°C байх бөгөөд хамгийн их халуун нь 7-8-р сард $+39.4^{\circ}\text{C}$, хамгийн их хүйтэн нь 1-2-р сард -43°C хүрдэг гэжээ. Жилд орох хур тунадасны хэмжээ 260-300 мм, нийт хур тунадасны 90% гаруй нь зөвхөн зуны улиралд унадаг байна.

Баянгол, Нарангийн гол болон түүний салбар жижиг голуудын хөрсний хөлдөлт, гэсэлт нь тухайн жилийн цаг агаарын хүчин зүйлээс шалтгаалдаг. Хөрсний хөлдөлт нь дунджаар 10 дугаар сарын дундаас дараа жилийн 5 дугаар сарын дунд хүртэл 200 гаруй хоног гадаргуугийн 2.7-3.8 м гүн хэсэгт явагддаг

байна. Хөрсний гэсэлт дунджаар 4 дүгээр сарын эхнээс 6 дугаар сарын эхний хооронд явагдана. Хөрсний хөлдөлтийн гүн нь хөрсний чийг, механик бүрэлдэхүүнээс хамаарч шавар шавранцарт 2.7 м, элсэнцэрт 2.9 м, элсэнд 3.4 м, хайрга, хайрганцар хөрсөнд 3.8 м байдаг байна.

Уул зүй: Төслийн талбай нь газар зүйн байршлын хувьд Хойд Хэнтийн хүдрийн бүсийн төвийн хэсэгт, газар зүйн мужлалын хувьд Хэнтийн уулархаг их мужийн, Хэнтийн мужийн, Бага Хэнтийн дэд мужийн захын тойрогт хамаарагдана. Газрын гадаргуугийн хувьд хэрчигдэл багатай, усан сүлжээний нягтшил өндөртэй үнэмлэхүй болон харьцангуй өндөржилт ихтэй, хөрс, ургамлын бүрхэвч сайн хөгжсөн талбай болно. Талбайн болон дүүргийн хувьд баруун хойд хэсгээр томоохон хөндий, нам уулс, гүвээ толгодорхог гадаргуу, бусад хэсгийг дунд өндөрлөг уулс эзэлнэ.

Төслийн талбай нь дунд өндөрлөгтэй уулсын мужид хамаарах бөгөөд сайр жалгаар нилээд хэрчигдсэн, дүүрэг нутгийн хувьд хамгийн нам цэг нь талбайгаас хойш орших Баянголын хөндийд 902.2 м м байдаг бол хамгийн өндөр цэг нь талбайгаас өмнө хэсэгт орших Индэртийн нурууны салбар уулсын нэг болох Хөх Асгат уул 1522.9 м өндөртэй байна. Дүүрэг нутгийн уулсын харьцангуй өндөр нь 100-300 м-ийн хооронд хэлбэлзэнэ.

Орд орчмын хамгийн нам цэг нь тусгай зөвшөөрлийн талбайн зүүн хойд өнцөгт байх бөгөөд энд цооногийн өндрийн хэмжилтээр 1019 м бол хамгийн өндөр цэг нь талбайн урд захад 1160 м орчим, харьцангуй өндөр нь 50-150 м байна.

Усан сүлжээ: Тус шороон орд нь Монгол орны усны сав газрын харьяаллаар Сэлэнгэ аймгийн Баянгол сумын Хараа голын сав газарт харьяалагддаг. Төслийн талбайн усан сүлжээнд талбайн баруун захаар Их Мухарын, зүүн талаар Бага Мухарын горхинууд урсана.

Эдгээр горхинууд нь жижиг хэмжээтэй бөгөөд тэдгээрээс хамгийн том болох Их мухартын гол нь 1-2 м өргөнтэй, 0.5-0.8 м-ийн гүнтэй урсгал түргэнтэй горхи юм. Бага мухартын горхи нь 1 м хүртэл өргөнтэй, 0.5 м хүртэл гүнтэй жижиг горхи юм. Эдгээр горхинууд нь байнгын тогтмол урсгалтай бөгөөд тэдгээрийн ус нь 10-р сарын сүүл үеэс хөлдөж, хавар 4-р сарын эхэн үеэр гэсдэг байна.

Ургамал, амьтны аймаг: Төслийн талбай нь экологи газарзүйн хувьд ойт, уул хээрийн бүслүүр гэж нэрлэж болох өвөрмөц ландшафтыг үүсгэж тогтсон бөгөөд уулын энгэр хажуугийн хэсэгт ойт хээрийн бүс ээлжлэн солигддог байна. Ой мод нь уулын арын хажуу дагуу ургах ба хээрийн бүс нь уулын өвөр, энгэр бэл, уулс хоорондын хөндий хоолойгоор ажиглагдаж байдаг. Уг нутаг нь Монгол орны хангайн бүсийн шинжийг илэрхийлсэн, ургалт харьцангуй шигүү 1 м² талбайд ургасан ургамлын тоо 60-100, өндөр нь 4-14 см хооронд хэлбэлзэх ба Хангайн хэв шинжийн нам уулсын нийлмэл цэцэгтэн, үетэн, буурцагтнаас гадна холтсон цэцэгтэн, тэргүүлэгч цэцэгтэн гэх зэрэг ерөнхийдөө түгээмэл байдаг овгууд нэлээд чухал үүрэг гүйцэтгэнэ. Наран голын дүүргийн амьтны аймаг баян, төрөл зүйл олонтой төвийн болон ойт хээрийн бүсийн хөхтний бүлгийн, олон

зүйлийн туурайтан, махан идэштэн оршдог нутаг юм. Төрөл бүрийн олон наст ургамал, үетнээс шивээт хялгана, хазаар өвс, хиаг, ерхөг, ботууль түүнчлэн агь, бударгана, цахилдаг зэрэг ургамал зонхилж ургана.

Дэд бүтэц, хүн ам: Төсөл хэрэгжих талбай нь Монгол орны төвийн бүсэд оршдог тул дэд бүтцийн хөгжил харьцангуй сайн. Замын Үүд-Алтанбулагийн босоо тэнхлэгийн засмал замаас 38 км зайд орших бөгөөд орон нутгийн шороон замаар саадгүй нэвтрэх боломжтой, Шарын гол сумаас 20 км зайд орших бөгөөд тус сум нь Транс-Монголын гол төмөр замтай 45 км урт биеэ даасан салаа замаар холбогддог.

Баянгол сум болон Шарын голын уурхай нь Төвийн цахилгаан дамжуулах сүлжээнд холбогдсон эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй. Мөн уг ордоос 5.0 км-т орших Шанд довын тариа бригад нь Шарын гол хоттой өндөр хүчдэлийн /6000в/ шугамаар холбогдсон, талбайгаас баруун хойш 7.0 км-т Шарын гол болон Баянгол сумыг холбосон өндөр хүчдэлийн шугам байдаг. Төсөл хэрэгжих талбайд хамгийн ойр орших Баянгол сум нь нийт 1590 өрхтэй, 5700 гаран хүн амтай.

Сумын хэмжээнд 100 гаруй аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа тогтмол явуулдаг. ХАА, газар тариалангийн үйлдвэрлэл болон уул уурхайн аж ахуйн нэгжүүд дийлэнх хувийг эзлэнэ.

Ил уурхайн хүчин чадал орд ашиглах хугацаа, ажлын горим

Ил уурхайн хүчин чадлыг төсөл захиалагч компанийн ажиллахад бэлэн байгаа уурхайн тоног төхөөрөмжийн хүчин чадал, элс угаан баяжуулах цехийн хүчин чадалд тулгуурлан, сар бүр ил уурхайн уулын ажлыг жигд байлгах зорилт тавин төлөвлөлөө. Ил уурхай нь сард 330.0 мян.м³ уулын цул хөдөлгөж, элс угаах цехийг тогтмол 30 мян.м³ элсээр ханган ажиллана. Уг хүчин чадалд тулгуурлан ордын ашиглалтын хугацааг тооцоход 6 сар байна.

Ил уурхайн ажлын горим: Ил уурхайн ажилчид 14/14 хоногийн ээлжийн системээр ажиллах ба хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна. Уурхайн хөрс хуулалтын ажлыг 5-р сараас 10-р сар хүртэл, элс угаалтын ажлыг 6-р сараас 10-р сар хүртэл үргэлжлэхээр тооцоолж ТЭЗҮ-ийг боловсруулав. Ил уурхайн ажлын горимыг дараах хүснэгтээр үзүүлэв.

Ил уурхайн уулын ажлын календарчилсан төлөвлөлт: Ил уурхайн уулын ажлын календарчилсан төлөвлөлтийг ордын уул геологийн нөхцөл, элс угаах цехийн хүчин чадал болон олборлолтод ажиллах техникүүдийн хүчин чадалд тулгуурлан гүйцэтгэсэн. Орд ашиглалтын 6 сарын хугацаанд нийт 2,02 сая.м³ уулын цул үүнээс 129.6 мян.м³ элс олборлож, 1.8 сая.м³ хөрс хуулна. Хөрс хуулалтын дундаж коэффициент 19.1 м³/м³ байна.

Элс олборлолтын төлөвлөгөө: Ордын элс олборлолтын төлөвлөгөөг төсөл захиалагчаас ирүүлсэн ТЭЗҮ боловсруулах техникийн ажлын даалгавар, угаан баяжуулах хэсгийн хүчин чадалд тулгуурлан сард дунджаар 22.0 мян.м³, орд ашиглалтын 6 сарын хугацаанд 129.6 мян.м³ элс олборлохоор төлөвлөсөн.

Хөрсний овоолгын төлөвлөгөө: Ашиглалтын эхний сард хуулах хөрсийг элс угаах далан барихад ашиглах ба далангийн хэмжээ 550.0 мян.м³ хэмжээтэй байна. Ашиглалтын 2 дахь сараас эхлэн хуулсан хөрсийг ил уурхайн ашиглагдсан орон зайд дотоод овоолго үүсгэх замаар хураана. Ашиглалтын хугацаанд нийт сийрэгжсэнээр 3.1 сая.м³ хөрс дотоод овоолгод хураана. Ил уурхайн олборлолт дууссаны дараа элс угаах даланд ашигласан хөрсийг мөн уурхайн ашиглагдсан орон зайг дүүргэж овоолно.

Элсний овоолгын төлөвлөгөө: Элс угаалтын ажил ил уурхайн уулын ажлаас 1 сарын дараа эхлэхээр тооцоолж ТЭЗҮ-ийг боловсруулсан. Элс угаан баяжуулах цехийг ажиллаж байх үед элсээр тасралтгүй хангах үүднээс угаах баяжуулах хэсгийн хүчин чадлаас хамааран 7-21 хоногийн элсний бэлтгэгдсэн нөөцтэй байхаар тооцоолж элсний овоолгын ажлын төлөвлөлөө.

Ил уурхайн уулын ажлын механикжуулалт:

Орд ашиглалтын хугацаанд нийт 2.02 сая.м³ уулын цул үүнээс 129.6 мян.м³ элс олборлож, 1.8 сая.м³ хөрс хуулна. Хөрс хуулалтын дундаж коэффициент 19.1 м³/м³ байна. “Сартуул Орд” ХХК нь өөрийн тоног төхөөрөмжөөр олборлолтын ажлыг явуулдаг.

Энэхүү ТЭЗҮ-д олборлолтын ажлыг уг тоног төхөөрөмжүүдээс явуулахаар тусгалаа. Ил уурхайн хөрс хуулалтын ажилд 7 м³ утгуурын багтаамжтай PC-1250SP-7 маркийн урвуу утгуурт экскаватор, элс олборлолтын ажилд 1.6 м³ утгуурын багтаамжтай Komatsu PC-300 маркийн экскаватор, хөрс тээвэрт 55 тн даацтай MT86H маркийн автосамосвал, элс тээвэрт 20 тн даацтай HOWO336 маркийн автосамосвал, хөрсний овоолго, шимт хөрсний овоолго болон шимт хөрс хуулах ажил, ил уурхайн мөргөцөгт CAT-D9T маркийн бульдозер ажиллана.

Элсний овоолго болон туслах ажилд ажиллах тоног төхөөрөмжийн тооцоо:

Орд ашиглалтын 6 сарын хугацаанд нийт 129.6 мян.м³ элс олборлоно. Элсний овоолго, зам, өндөр хананы аюулгүйн хөмсөг тавих болон бусад туслах ажлуудыг 3 м³ утгуурын багтаамжтай SDLG-LG953 маркийн утгуурт ачигч ажиллана.

Техникийн бүтээлийн тооцоогоор ил уурхайн ашиглалтын саруудад SDLG-LG953 маркийн 3 м³ утгуурын багтаамжтай утгуурт ачигч 2 ш шаардлагатай байна.

Ил уурхайн зам арчилгаа болон усалгаанд ажиллах тоног төхөөрөмжийн тооцоо: Уурхайн замын нөхцөл байдлаас автосамосвалын хөдөлгөөний эрчим, бүтээл, эвдрэл гэмтэл зэрэг хамаардаг. Иймд уурхайн замыг байнга засаж сайжруулан ашиглах ба хуурайшилт ихтэй улирлуудад замыг усалж тоос шороо босохоос урьдчилан сэргийлэх ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

Дэд бүтэц: Бага Мухарын амны дунд хэсгийн алтны шороон орд нь Сэлэнгэ аймгийн Баянгол суманд дэд бүтэц хөгжсөн бүс нутагт оршдог. Төсөл хэрэгжүүлэгч “Сартуул Орд” ХХК нь дэд бүтцийн бүх асуудлыг Монгол Улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль журмын дагуу хийж гүйцэтгэнэ.

Цахилгаан хангамж: Шарын гол сумын 110/6кВт-ын хүчдэлтэй 21-р дэд станцаас Буянтын станц руу 11 км 6/10кВт цахилгаан дамжуулах агаарын шугам татсан байдаг бөгөөд Бага мухарын амны дунд хэсгийн алтны уурхай руу тус дэд

станцаас салбарлуулан 3.8 км-ийн урттай 10кВт-ын хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын шугам татаж уурхайг цахилгаанаар хангана.

Цахилгааны хэрэглээ: Ил уурхай, угаан баяжуулах хэсэг, хотхон болон бусад ашиглалтын туршид цахилгаан эрчим хүч хэрэглэх цахилгаан хэрэглэгчдийн цахилгаан ачаалал, тэдгээрийн цахилгаан эрчим хүчний зарцуулалтыг тооцов. Уурхайн ашиглалтын үед цахилгааны үндсэн гурван хэрэглэгч байна. Үүнд:

- Ил уурхай
- Угаан баяжуулах хэсэг
- Хотхон

Ил уурхайн цахилгааны хэрэглээ: Ил уурхайн цахилгааны хэрэглэгчдэд засварын газрын тоног төхөөрөмжүүд болох компрессер, гагнуурын аппарат, дугуй задлагч болон гэрэлтүүлэг зэрэг багтана.

Угаан баяжуулах хэсгийн цахилгааны хэрэглээ: Угаах баяжуулах хэсгийн цахилгааны хэрэглэгчдэд скруббер, баяжуулах ширээ, усны насос, цэвэр усны насос зэрэг үндсэн тоног төхөөрөмжүүд багтана.

Хотхоны цахилгааны хэрэглээ: Хотхоны цахилгааны хэрэглэгчдэд уурхайн ажилчдын хоол унд болон ариун цэврийг хангахад ажиллах тоног төхөөрөмжүүд багтана.

Төслийн нийт цахилгааны хэрэглээ: Орд ашиглалтын хугацаанд цахилгааны хэрэглээ 488.48 МВт ба сард дунджаар 82.62 МВт байна.

Уурхайн усан хангамж: Уурхайн унд-ахуйн буюу хотхоны усны хэрэглээг төсөл хэрэгжих шатанд гүний худаг өрөмдөн хангах бөгөөд хөрөнгө оруулалтыг эдийн засгийн тооцоонд тусгав. Хотхоны дэргэд ундны ус хадгалах зориулалттай 20 м³-ийн сав байрлуулах ба 2-3 хоногт нэг удаа цэнэглэнэ.

Харин ил уурхай болон угаан баяжуулах хэсгийн усны хэрэглээг шүүрэлтийн усаар хангана. Ил уурхайд шүүрч орж ирэх усыг “Их худаг”-ийн аргаар тооцоход тухайн жилийн ил уурхайн карьераас хамаарч 21.3-23 л/с шүүрч орж ирэхээр байна. Энэ нь угаан баяжуулах хэсэг болон ил уурхайн усны хэрэглээ болох 14.63 л/с-ийг хангаж байна. Ил уурхайд шүүрч орж ирэх усыг зумпанд цуглуулах ба зумпнаас угаан баяжуулах хэсгийн цэвэр усны болон эргэлтийн усан сан руу татаж ашиглана. Мөн цаашид ашиглалтын явцад цооногийн аргаар ус шүүрүүлэлтийг хийх, нөөцлөх аргачлалыг судлахыг захиалагчид зөвлөж байна.

Уурхайн ашиглалтын үеийн усны нийт хэрэглээг технологийн тооцоо болон уул уурхайн салбарын нормд үндэслэн тооцсон ба цэвэр усны дараах гурван гол хэрэглэгчид байна. Үүнд:

- Ил уурхай
- Угаан баяжуулах хэсэг
- Хотхон

Ил уурхайн усны хэрэглээ: Ил уурхайн усны хэрэглэгчдэд уурхайн зам, талбайн усалгаанд ажиллах техник, тоног төхөөрөмжүүд байна.

Ил уурхайн усны хэрэглээнд 0.3 л/с усны эх үүсвэр шаардлагатай ба орд ашиглалтын 7 сарын хугацаанд хоногт 25.95 м³/хоног ус хэрэглэхээр байна.

Элс угаан баяжуулах хэсгийн цэвэр усны хэрэглээ: Элс угаан баяжуулах хэсэгт ашиглах усыг БОНХАЖ-ын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын дагуу шаардагдах усны хэмжээг тооцсон. Эргэлтийн ус ашиглалт ойролцоогоор 76% орчим байна.

Хотхоны усны хэрэглээ: Уурхайд байрлах ажилчны тоо хамгийн ихдээ 100 хүн, нэг хүний хоногт хэрэглэх усны хэмжээг БОНХАЖ-ын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 7 дугаар хавсралтын дагуу 150 л/хоног хүн байхаар тооцсон.

Төслийн нийт усны хэрэглээ: Орд ашиглалтын хугацаанд 172.6 мян.м³ усыг зам усалгаа, элс угаан баяжуулах хэсэг, ажилчдын унд-ахуйн усны хэрэглээнд ашиглах бөгөөд 15.94 л/сек усны ундарга шаардлагатай байна. Төслийн нийт усны хэрэглээ болон шаардлагатай ундаргыг тооцон дараах хүснэгтэд үзүүлэв.

Шатахуун түгээх станц, агуулах: Уурхайн түлшний сарын дундаж хэрэглээ 75.6тн, дизелийн масло 3.8тн, бусад төрлийн шатах тослох материал 0.57тн тус тус хэрэглэнэ. ШТМ-ыг 2 сарын нөөцтэй байхаар бодож түлш хадгалах 20тн-ын багтаамжтай ган сав 1 шир, дизелийн масло болон бусад тос материалыг зориулалтын савтай нь тус тус хадгалахаар төсөлд тусгав.

ШТМ-ын агуулахыг гал, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагын норм дүрмийн дагуу байрлуулан зориулалтын тоноглолоор хангасан байна.

Авто зогсоол: Уурхайд дээр байнга ажиллах тоног төхөөрөмж нь уурхайн ачигч машин, экскаватор, утгуурт ачиг, бульдозер, уурхайн бусад ажилд суудлын машин, бага оврын ачааны машин, усалгааны машин байх бөгөөд эдгээр машинуудад зориулж машины түр зогсоол байгуулна.

Авто зам: Бага мухарын амны дунд хэсгийн алтны шороон ордын талбай нь Улаанбаатар хотоос Сэлэнгэ аймгийн Баруун хараа хот хүртэл 150 км хатуу хучилттай замаар, Баруун хараа сумаас Баянгол сум хүртэл сайжруулсан шороон замтай, бусад сум сууринтай шороон авто замаар холбогддог. Уурхайн тээвэр нь:

- Ил уурхайн дотоод тээвэр
- Уурхайн гадаргуугийн дотоод тээвэр
- Гадаад тээвэр гэсэн үндсэн 3 хэсгээс бүрдэнэ.

Гадаргуугийн тээвэр нь уурхайгаас гарах уулын цулыг хоосон чулуулгийн овоолго болон баяжуулах үйлдвэрийн элс хүлээн авах хэсэг хүртэл тээвэрлэнэ. Мөн хоосон чулуулгийг уурхайн ухшийг дүүргэх, дотоод овоолго үүсгэх зэрэг тээвэрлэлт хийгдэнэ.

Түүнчлэн усалгааны машин нь замын тоосжилтыг багасгах зориулалтаар ажиллана. Уурхайн дотоод хэрэгцээний машинуудын гүйлтийн жилийн төлөвлөлтийг дараах байдлаар илэрхийлэв. Үүнд:

1. Жийп, ачааны машин Маршрут:
 - Улаанбаатар-Бага мухарын ам уурхай – 7 хоногт 1 удаа: км, жилд 15,600;
 - Уурхай-Баянгол сум – 7 хоногт 1 удаа: 40км, жилд 4,160км.
2. Ажилчдын автобус. Маршрут:
 - Улаанбаатар-Бага мухарын ам уурхай – 7 хоногт 1 удаа: км, жилд 15,600;
 - Уурхай-Баянгол сум – 7 хоногт 1 удаа: 40км, жилд 4,160км.
3. Усалгааны машин. Маршрут:
 - Уурхай – Худаг – 2 хоногт 1 удаа: 1км, жилд 365км;

Харилцаа холбоо: Төслийн талбайд хамгийн ойр суурин газар болох Шарын гол болон Баянгол сумын төв эдийн засаг, дэд бүтэц нь дунд зэрэг хөгжиж буй сууринд хамрагдана.

Тус сум нь гурван багтай, 5,632 хүн амтай бөгөөд 90 орчим хувь нь халх, үлдсэн нь бусад угсаатнаас бүрдэх ба голлож тариалан, мал аж ахуй эрхэлж амьдардаг.

Сумын төвд нь төр захиргааны байгууллага, соёлын төв, дунд сургууль, эмнэлэг, цэцэрлэг, холбоо, үүрэн телефоны дэд станц, ШТС, өндөр хүчдэлийн дэд станцууд бий. Уурхайн нь холбоо харилцаандаа:

- Интернэт үйлчилгээ- хэрэглэдэг
- Утасны холбоо – кемпээс 100 м зайнд бүх сүлжээ барьдаг.

ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Нөхөн сэргээлтийн ажил: Тус төслийн хэмжээнд 2026 онд нийт 2,02 сая.м³ уулын цул үүнээс 129,6 мян.м³ элс олборлож, 1,8 сая.м³ хөрс хуулалтын ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн.

Агаар мандаал: Тээвэрлэлтийн үед тоос шороо босч агаар мандлыг бохирдуулна. Мөн дотоод шаталтаас гарах утаа тортог агаар орчны хэсэгчилсэн бохирдолтыг бий болгоно.

Ус: Үйлдвэрлэлийн явцад шаардагдах усыг ихэвчлэн хөрсний усаар хангана. Ундны болон үйлдвэрлэлийн усан хангамжийн эх үүсвэр нь гүний худаг бөгөөд эндээс ус соруулах болон тээвэрлэх явцад автомашины шатахуун асгарч эх үүсвэрийг бохирдуулж болзошгүй. Мөн өрөмдлөгийн явцад газрын доорхи уст үеүд холилдох.

Хөрс, ургамал, газар: Тээвэрлэлтээс үүдэн хөрсний бүтэц эвдэрч, үржил шим буурч ургамал устгах, талхлагдах зэргээр нөлөөлөлд өртөх ба орчны гоо үзэмж буурна.

Газрын гадарга, хөрс ургамал нь ахуйн хаягдал, шатах, тослох материалаар бохирдож болзошгүй.

Зэрлэг амьтан, мал: Зэрлэг амьтад автомашины чимээнээс дайжих, мал амьтан ухсан нүх сувагт унаж бэртэх, үхэж хорогдох зэрэг сөрөг үр дагавар гарч болзошгүйтэй холбогдуулан хамгаалалтын тор татаж сөрөг үр дагаварыг бууруулах арга хэмжээ авч хамгаалан ажиллана.

Ажилчид, оршин суугчийн эрүүл мэнд: Орчны тоосжилт, тоног төхөөрөмжийн ажиллагааны үед гарах дуу чимээ, ажиллагаа оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж, хөдөлмөрийн чадварыг бууруулж болзошгүй. Үүний зэрэгцээ үер, аянга цахилгаан зэрэг байгалийн гэнэтийн аюулд өртөж болзошгүй. Үйлдвэрлэлийн явцад ажилчид ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа байнга өгч ажиллана.

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

“Сартуул орд” ХХК-ийн Бага мухарын амны алтны шороон ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийг илрүүлэх, тэдгээрийн үр дагаврыг тогтмол хянах, хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах үүрэгтэй.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд “Сартуул орд” ХХК-ийн Бага мухарын амны алтны шороон ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн бөгөөд төсөл хэрэгжүүлэгч үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш жил бүр энэхүү үнэлгээгээр тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, тэдгээрийг арилгах бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатай. Ингэхдээ байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдээс гарч буй үр дагавар, бодит байдалтай уялдуулан улам баяжуулж, сайжруулан мөрдлөг болгох хэрэгтэй. Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 11 сарын 1-ний дотор Баянгол сумын ЗДТГ-т танилцуулан, 12 дугаар сард багтаан БОАЖЯ-д хүргүүлж дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг БОАЖЯ-аар батлуулах үүрэгтэй.

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээр тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөөг нөлөөлөлд өртөж болзошгүй байгалийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр авч үзэж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг таван жилээр тооцсон болно.

ЭРХЗҮЙН ҮНДЭС БА ГОЛ ШААРДЛАГА

БОМТ нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсаныг баримтлан БОХТ, ОХШХ-ийг боловсруулав.

БОМТ-г боловсруулахдаа Монгол Улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 дугаар тушаалын 2-р хавсралтаар батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ийн 4-р хэсэг болох “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”, 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” зэргийг удирдлага болголоо.

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон 2012 онд шинэчлэн батлагдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд (Төрийн мэдээлэл, 2012 оны 22 дугаар) аливаа төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрдэл хэсэг болох байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар заасан.

Дээрх хуулийн шаардлагын Бага мухарын амны алтны шороон ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанаас тухайн нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлын хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулав.

БҮЛЭГ 1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагаанаас гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх орчноор буюу агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөрс болон ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийг бууруулах, усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, амьтны аймагт үзүүлж болзошгүй нөлөөллийг бууруулах арилгах зэрэг чиглэлүүдээр бүлэглэн авч үзсэнийг хүснэгтэд бүрэн эхээр тусгав. Төсөл хэрэгжүүлэгч энэхүү БОМТ-г бүрэн хэрэгжүүлсэн нөхцөлд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллөөс зайлсхийх, тэдгээрийг бууруулах, арилгах бүрэн боломжтой.

1.1. Агаар орчныг хамгаалах чиглэлээр хийгдэх ажлууд:

Зорилго: Уурхай ажилчдыг эрүүл аюулгүй орчинд ажиллах амьдрах нөхцлийг бүрдүүлэх, хүрээлэн буй орчны тэнцлийг хадгалах зорилгоор орчны агаар дахь хими, физикийн гаралтай түгээмэл бохирдуулагчийг стандарт хэмжээнээс хэтрүүлэхгүй байх.

Хүснэгт 1. Агаарт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөлийн арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах арга хэмжээ	Хэмж их нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хүнд машин механизмын хөдөлгөөнөөс тоосжилт үүсэх	Замын тоосжилтыг бууруулах зорилгоор усалгаа хийх	Уурхайн дотоод тээврийн зам талбай	км	300,000.00	Тухай бүрт	300,000.00	Тухай бүрт	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Агаарын тухай болон бусад хууль, холбогдох дүрэм журам, стандарт
2		Тээврийн хэрэгслийн хурдыг хязгаарлах тэмдэг зааврыг мөрдөж ажиллах	Уурхайн дотоод тээврийн зам талбай	ш	100,000.00	Нийт зам талбай	100,000.00	Тухай бүрт	MNS6278:2011 хүнд даацын тээврийн хэрэгсэл, Техникийн ерөнхий шаардлага, Монгол Улсын Хууль, Замын хөдөлгөөний тухай, Монгол улсын замын хөдөлгөөний дүрэм
3	Уурхайн олборлолтын явцад 76.8 мян.м³ хөрс хуулах бөгөөд хөрс хуулалтын явцад ухаж ачих, тээвэрлэх овоолгод байршуулах зэрэг үйл ажиллагаанаас тоосжилт үүсэх	Уурхайн дотоод замын сүлжээг хайрга чулуу, мод ашиглан сайжруулсан шороон зам болгох Дотоод зам талбайн усалгаа хийх	Уурхайн дотоод, гадаад орчин	Дотоод төлөвлөлтөөр		Үйл ажиллагааны зардалд тусгах		2026	
4	Машин, механизмаас гарах хорт хий агаарыг бохирдуулах	Авто тээврийн хэгсэлд ногдох агаарын бохирдолын төлбөрийг агаарын бохирдолын төлбөрийн тухай хуульд заасан хувь, хэмжээгээр төлөх	Уурхайн хэмжээнд	ш	19,000.00	20	380,000.00	6-р сарын 01-с өмнө	Агаарын бохирдолын төлбөрийн тухай хууль
		Нийт					780,000.000		

1.2. Усан орчинг хамгаалах чиглэлээр хийгдэх ажлууд:

Зорилго: Уурхайн ажилчдын амьдрах орчинд ямар нэгэн бохирдолгүй усыг унд ахуйнд хэрэглэх, уурхайн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад оршино.

Хүснэгт 2. Усан орчинд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөлийн арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах арга хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ундны усны чанарын шаардлага хангахгүй байх	Усны хянал мониторингийг унд ахуйн ус болон, цэвэрлэх байгууламжийн гаралтын уснаас жилд 2 удаа 5-6 сард болон 9-10 сард дээж авч шинжлүүлэх	Уурхайн хэмжээнд	ш	60,000.00	2	120,000.00	Жилдээ	Усны тухай хууль
2	Уурхайн ашиглалтын нийт жилд 172.5 мян.м ³ ус ашиглах бөгөөд Ил уурхайд 4.426.94, Баяжуулах хэсэгт 165.274.2, Хотхон 3.165 мян.м ³ ус ашиглана.	Худгийг тоолууржуулах	Уурхайн худаг	ш	Үйл ажиллагааны зардалд тусгах			2022-2026	MNS 0900: 2018. Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
3	Халдварт өвчин үүсэх	Усны нөөцийн саванд ариутгал хийлгэх	Нөөцийн сав	ш	50,000.00	2	100,000.00	Жилдээ	

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөлийн арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөлийн хамрах арга хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
4	Ил уурхайн гүн доошлохын хэрээр усны шүүрэлт ихсэж, уурхайгаас зайлуулах усны хэмжээ нэмэгдэх	Уурхайн олборлолтоос үүсэх шүүрлийн усыг шавхах дамжуулах хоолойн эд ангийг тогтмол шалгах, төлөвлөгөөт засваруудыг тогтмол хийх	Уурхай дотор	Сард 1 удаа	Үйл ажиллагааны зардалд тусгах			2026	Байгалийн нөөц ашигласаны тухай хууль
5		Шүүрлийн усаар зам талбай услах	Уурхайн дотоод зам талбай	м³	Үйл ажиллагааны зардалд	Тухай бүрт	Үйл ажиллагааны зардалд	Тухай бүрт	
6	Гол мөрний урсац, бүрэлдэх эх усны сан бүхий газрын, хамгаалах бүс, ойн сан бүхий газартай давхцалтай эсэх	Мэргэжлийн байгууллагаар ойн сан бүхий газартай давхцалтай эсэх лавлагааг гаргуулж анхаарч ажиллах	Уурхайн ашиглалтын талбай	га	Үйл ажиллагааны зардалд тусгах			2026	Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан, бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль
		Нийт					220,000.00		

1.3. Хөрсний эвдрэл, элэгдэлд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах:

Зорилго: Уурхайн үйл ажиллагаанаас үүссэн хөрсний элэгдэл, эвдрэл бохирдлыг багасгах байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, уурхайгаас хуулсан шимт хөрсний үржил шимийг алдагдуулахгүйгээр хадгалах, арчлах.

Хүснэгт 3. Хөрсөнд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөлийн арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах арга хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
